

ТЕЛЕ СЭТГҮҮЛ ЗҮЙН СУРГАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
ТУЛГАМДСАН АСУУДАЛ

М.Дэлгэрцэцэг*

* "Их Монгол" дээд сургуулийн багш, магистр

Түлхүүр үг: телевиз, багш, окутан, хөтлөгчийн ур чадвар, эфирийн соёл.

21-р зууны мэдээллийн хүчирхэг хэрэгсэл болсон телевизийн сэтгүүлч, уран бүтээлчдийг бэлтгэн гаргахад их, дээд сургуулиуд хэрхэн сургалтаа явуулж, юунд анхаарвал зохих вэ гэдгийг дурдахыг зорьлоо. Хүн төрөлхтөн анх телевиз гэдэг үгтэй танил болсноор эдүгээ 107 жил, телевизийн өргөн нэвтрүүлэг эхэлснээр дал шахам жил өнгөрчээ. Үзэгч кино театрт биш, харин нэвтрүүлэх танхимаас алсад гэртээ сууж, жижигхэн дөрвөлжин хайрцгаар юм үзнэ гэдэг гайхамшиг байлаа.

Одоогоос дөчин нэгэн жилийн тэртээ Монголд анх телевиз байгуулагдаж байсан тэр цагаас эхлэн өнөөдөр телевизүүдийн тоо 10 хол давжээ. Шинэ шинэ телевизүүд байгуулагдсаар хүмүүсийн мэдээлэл авах орон зай, сонголт улам бүр өргөн болсоор байна.

Улс нийгэм хөгжихийн хэрээр телевиз ч, түүний үзэгчид ч өөрчлөгдөн хөгжсөөр байна. Тиймээс телевизийн уран бүтээлчдийн мэдлэг, мэргэжлийн ур чадвар хамгаас өндөр, бүхнээс шинэлэг байх ёстой гэж МУИС-ийн багш, доктор Ю.Эрдэнэтуяа хэлсэн байдаг.

1992 оноос "Чөлөөт телевиз", "Мэдээлэл арилжааны чөлөөт суваг", "Жолоо", "Улаанбаатар" зэрэг телевиз анхныхаа нэвтрүүлгийг хийж эхэлснээр манай оронд телевизийн систем бүрэлдэн тогтох эхлэл тавигджээ.

Эдүгээ нийслэл болоод хөдөө орон нутагт олон телевиз үйл ажиллагаагаа явуулж байна. 2000 оныг хүртэл "Ийгл" анхны хувийн телевиз болох "25 суваг телевиз", "Улаанбаатар" телевизүүд үйл ажиллагаагаа явуулж байсан бол 2003 оноос эхлэн хувийн чөлөөт телевизүүд жил дараалан байгуулагдлаа. Өнөөдрийн байдлаар Улаанбаатарын хэмжээнд МҮОНТВ, UBS, TV-5, TV-9, MN-25-р суваг, ТМ, TV-8, С-1, Ийгл, SBN, NTB, "Боловсрол" суваг зэрэг

телевизээс гадна кабелийн телевизүүд үүсч хөгжин нийгмийн хөгжилд зохих хувь нэмрээ оруулан бусад ХМХ-тэй амжилттай өрсөлдөж байна. Телевизүүд олноор бий болж өнөөдөр хэвлэл мэдээлийн хэрэгсэлд онцгой байр суурийг эзэлж байна. Телевиз хөгжиж тэнд ажиллах сонирхолтой залуусын тоо ч олширсон.

Улмаар телевизээр гарч байгаа сэтгүүлч хөтлөгчдийн ур чадварын асуудал хурцаар тавигдах болсон. Эфирийн соёл, хэл ярианы соёл, биеэ авч буй байдал, үзэгчдээ үл хүндлэх зэрэг дутагдалтай талууд ихээр ажиглагдах болсон. Хөтлөгч нэвтрүүлэгчдэд:

- Гадаад төрх, дуу хоолойн өнгө сайн байх,
- Хэл ярианы соёлтой байх,
- Эфирийн соёлтой байх,
- Үзэгчдийг өөртөө татах чадвар буюу харилцааны соёл байх,
- Мэргэжил боловсрол, мэргэжлийн мэдрэмжтэй байх зэрэг шаардлага тавигддаг.

Эдгээр шаардлагыг хангасан чадварлаг сэтгүүлчдийг бэлтгэн гаргахад их, дээд сургуулиудын сургалт чухал

нөлөө үзүүлэх юм. Өнөөдөр телевизийн хөтлөгчид хэр ур чадвартай байна гэсэн асуулт гарч ирнэ. Үүний дагуу үзэгчдээс судалгаа авахад судалгаанд оролцогчдын 65 хувь нь телевизийн хөтлөгчид тааруу гэсэн хариулт өгч байна. "Хөтлөгчид илүү ур чадвартай болохын тулд юу анхарах ёстой вэ?"

гэсэн асуултанд телевизүүд мэргэжлийн хүнийг авч ажиллуулах ёстой гэж 21,5%, сэтгүүлч бэлтгэдэг сургуулиудын сургалтын хөтөлбөрийг чанаржуулах гэж 47,5%, бусад орны хөтлөгч нэвтрүүлэгчидтэй туршлага солилцох гэж 52 хувь

«

Хөтлөгч нэвтрүүлэгчдэд:

- Гадаад төрх, дуу хоолойн өнгө сайн байх,

- Хэл ярианы соёлтой байх,

- Эфирийн соёлтой байх,

- Үзэгчдийг өөртөө татах чадвар буюу харилцааны соёл байх,

- Мэргэжил боловсрол, мэргэжлийн мэдрэмжтэй байх зэрэг шаардлага тавигддаг.

Эдгээр шаардлагыг хангасан чадварлаг сэтгүүлчдийг бэлтгэн гаргахад их, дээд сургуулиудын сургалт чухал нөлөө үзүүлэх юм.

»

нь тус тус хариулжээ. Телевизээр ярьж хэлж байгаа хүнийг дагаж ард түмэн, хүүхдүүд сурдаг, нэг үгээр хэлбэл ярианы соёлын хөтөч нь болж байдаг. Гэтэл хөтлөгчид ямар ч үгийн баялаггүй, гудамжны үл ойлгогдох, өөрсдөө ч ойлгохгүй үг хэллэгээр ярьж байна.

Соёл судлаач С.Жаргал "Утга зохиол урлаг" сонинд өгсөн ярилцлагадаа "Телевиз нь бодлогын хувьд сэтгүүлчдээс ур чадвар шаарддаг салбар. Сэтгүүлчдээр дамжиж нэвтрүүлэг ард түмэнд хүрдэг. Сүүлийн үед хөтлөгчид

гэж алиалагчид шиг хүмүүс гарч ирлээ. Хэл соёлгүй, наад захын үгийн сонголтгүй, мэдлэг мэдрэмжгүй охид бараг телевизээр гарч байна" гэж ярьсан байдаг. Тэгвэл энэ бүхэн юутай холбоотой вэ?

Телевизийн уран бүтээлчид ур чадвартай байх гол үндсийг нь сэтгүүл зүйн сургалтаар тавьж өгөх ёстой гэж үздэг.

Өнөөдөр улсын хэмжээнд сэтгүүлч бэлтгэдэг 21 их, дээд сургуульд 1500 гаруй оюутан суралцаж, жил бүр 300-350 оюутан төгсөн гарч байна. Сэтгүүлч мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудаас төгсөөд хэвлэл мэдээллийн ямар салбарт ажиллах сонирхолтой вэ гэсэн асуултанд тухайн оюутнуудын 70-80 хувь нь телевизийн сэтгүүлч болно гэсэн хариултыг өгдөг. Энэ нь телевизээр гарч байгаа хэн нэг алдартай сэтгүүлч хөтлөгчдийг хараад сайхан санагдах юм уу, олны танил хүн болно, нөгөө талаар тааруухан сэтгүүлчид ажиллаад байгаа учраас телевизээр гарах нь амархан юм шиг санагдах болсон.

Сургуулиа төгсөөд телевизэд ажиллахаар очихдоо хэрхэн бэлтгэгдсэн байдаг, камер, микрофонтой хэрхэн харьцаж сурсан, эфирийн соёлын талаар ямар ойлголттой болсон бэ гэдэг нь сургалтын явцад олж авсан мэдлэгтэй холбоотой. Сэтгүүлч бэлтгэж байгаа зарим их, дээд сургуулиудын теле сэтгүүл зүйн сургалт хэрхэн

явагддаг талаар судалгаа явуулсан юм. Судалгаандаа теле сэтгүүл зүйн хичээлийн долоо хоногийн цаг хэд вэ, хэдэн улирал ордог, хичээлийг мэргэжлийн багш ордог уу, теле студитэй юу, телевизийн дадлагын хичээлийг ямар тоног төхөөрөмж дээр ордог, теле сэтгүүл зүйн хичээлийн сургалтандаа ямар үнэлгээ өгөх вэ, телевизийн мэдээ ямар бүтэцтэй зэрэг асуултанд хариулт авсан юм.

Теле сэтгүүл зүйн хичээл ихэнх сургуулиудад 64-96 цагаар нэг улирал ордог бол РТДС-д 192 цагаар 4 улирал орж байна. Сургалтын цагийн зөрүүгийн хувьд авч үзэхэд теле сэтгүүлчийн уран чадварын асуудал гарч байгаа юм. Сэтгүүлч бэлтгэж байгаа их, дээд сургуулиудын теле сэтгүүл зүйн багш нар үндсэн бөгөөд мэргэжлийн хүмүүс ордог гэж байна. Теле сэтгүүл зүйн сургалтын чанарт нөлөөлөх нэг үндсэн үзүүлэлт нь оюутнуудыг практикт сургах телевизийн студитэй байх юм. Теле студид хэрэглэгдэх иж бүрэн тоног төхөөрөмжтэй сургуулиуд өнөөдрийн байдлаар хуруу дарам цөөн байна. Зарим нь камер, телевиз төдийхнийг сургалтандаа хэрэглэж байгаа бол огт тоног төхөөрөмжтгүй сургуулиуд ч олон байгааг дурдах нь зүйтэй. Теле студигүй сургуулиудын оюутнууд радио, телевизийн байгууллага дээр очиж дадлага хийх явцдаа танилцдаг байна. Дөрвөн жил сэтгүүлчийн мэргэжлээр суралцан

төгсгөж байгаа оюутнууд маань аль нэг телевизэд очоод камер, микрофонтойгоо харьцаж мэдэхгүй, телевизийн мэдээ ямар бүтэцтэйгээр бичигдэхийг ч мэдэхгүй байх тохиолдол цөөнгүй байгааг телевизийн мэргэжилтнүүд хэлж байна. Наад зах нь микрофоноо зөв барьж хүнээс ярилцлага авах чадварыг эзэмшээгүй, хэт ам руу нь тулгаж барих, нэг бол хэт холоос зэрэг дутагдалтай байдаг. Үүнд анхаарч сайн мэргэжилтэн боловсон хүчнийг сургуулиуд бэлдэх хэрэгтэйг анхааруулж байсан. Судалгаанд оролцсон оюутнуудаас телевизийн мэдээ ямар бүтэцтэйгээр бичигддэг талаар асуухад лид, дүрс, синхрон, субтитр, стэнд ап зэрэг нь мэдээг бүрдүүлнэ гэдгийг хэлж байсан нь сайшаалтай ч харамсалтай нь зарим оюутнууд огт мэдэхгүй гэсэн хариултыг ч өгч байв.

Судалгааны хамгийн гол асуулт нь сургуулийнхаа теле сэтгүүл зүйн сургалтанд ямар үнэлгээ өгөх вэ гэсэн асуултанд РТДС-ийн оюутнууд дангаараа 100% сайн гэж үнэлсэн бол бусад сургуулиудын оюутнуудын 65 хүртэл хувь нь сайн гэж дүгнэжээ.

Эндээс харахад РТДС-ийн оюутнууд теле сэтгүүл зүйн хичээлийн сургалтын чанартаа 100% сайн гэсэн үнэлгээг өгсөн нь тус сургууль нь МҮОНТВ-ийн бааз, суурин дээр байгуулагдсан, теле студийн бүрэн тоног төхөөрөмжтэй, телевизэд олон жил ажилласан сэтгүүлч, уран

бүтээлчид багшилдагтай холбоотой юм.

Телевизийн уран бүтээл, тэнд ажиллаж байгаа сэтгүүлч, хөтлөгчдийн ур чадвар олны нүдэн дээр ил байдаг учраас шүүмжлэлд хамгийн их өртөж, тэр хэрээр сэтгүүлч бэлтгэдэг их, дээд сургуулиудын сургалтын чанар, бэлтгэн гаргаж байгаа сэтгүүлчдээр тодорхойлогдож яригдах болсон.

Энэ бүхнээс үүдэн дараах дүгнэлтүүдийг хийж байна. Үүнд:

Мэдээллийн эрин зуун эхэлж, шинэ дэвшилтэт техник технологиуд бий болсоор байгаа энэ үед сэтгүүлч бэлтгэж буй их, дээд сургуулиуд материаллаг бааздаа анхаарч, теле студитэй болж байгаа нь сайшаалтай юм. Гэхдээ РТДС-ийн оюутны хариултыг эс оролцуулбал теле сургалтын явцыг дундаж гэж хариулсан хувь үлэмж давамгайлж байгаа юм.

Телевизүүд олноор бий болсон өнөө үед сэтгүүлч зөвхөн микрофон барьж сурвалжлага авахаас гадна бичсэн мэдээнийхээ дүрсийг оруулаад эвлүүлдэг болох шаардлагыг тавьж байгаа билээ. Иймд сургуулиуд тоног төхөөрөмжөө чанаржуулж, тоог нь олшруулахын зэрэгцээ монтажны программыг тусгайлан олныг хамарч заах хэрэгтэй болж байгаа юм. Телевизийн сэтгүүлч болох гэж шийдсэн бол зураг авах, эвлүүлэх талаар тодорхой ойлголт, мэдрэмжтэй болж төгсөх нь чухал болж байна.

Түүнчлэн теле сэтгүүл зүйн хичээлийг 2-р курсээс нь эхэлж тодорхой үе шаттайгаар орж, цаг, кредитийг нэмэгдүүлж, практик давамгайлсан сургалтыг явуулах шаардлагатай байна.

Мөн ихэнх сургуулиудад хөтлөгчийн ур чадварын хичээлийг тусгайлан

ордоггүйгээс төгсөг-

чид нь телевизийн

сэтгүүлч хөтлөгчийн

шаардлагыг хангаж

чаддаггүй. Ихэвчлэн

СУИС-ийн жүжигч-

ний анги төгссөн,

нэг бол сэтгүүлчийн

мэргэжил эзэмшээ-

гүй, эфирийн царай-

тай хүмүүсээр хөт-

лөгч хийлгэж, сэт-

гүүлчдийн орон зайг

эзлэх болсон. Теле нэвтрүүлэг

хөтлөгчөөр дамжин үзэгчдэд хүрдэг

практик давамгайлах болсон одоо үед

хөтлөгчийн уран чадварын хичээлийг

сэтгүүлч бэлтгэдэг их, дээд сургуулийн

хичээлийн программд оруулж өгөх,

сургуулиуд теле сэтгүүл зүйн сургал-

тын хөтөлбөртөө өөрчлөлт шинэчлэл-

түүдийг байнга хийж, боловсруулж

байх шаардлагатай байна.

Сайн сэтгүүлч байна гэдэг их юм

мэддэг байх ёстой. Бүх шинжлэх

ухааны талаар ерөнхий ойголттой

байж хүмүүстэй ярилцлага хийнэ.

Эрдэм мэдлэгтэй хүмүүсийг асуултанд

унатал нь харилцан ярилцаж байж

сайн сэтгүүлч байна. Ерөнхий мэдлэг байхгүйгээс наад захын нэр томъёог мэдэхгүй байна. Иймд ерөнхий мэдлэгийн цар хүрээг дээшлүүлэх тал дээр сургуулиуд сургалтандаа тусгаж анхаарах хэрэгтэй байна.

Мөн телевизэд шавь төвтэй сур-

галт чухал гэсэн

санал байна. Теле-

визийн туршлага-

тай сайн сэтгүүлч-

дийг болон сайн

багш нарыг дагал-

дуулан сургах сур-

галт хэрэгтэй. Тэд-

нийг дагалдан су-

ралцсанаар ча-

нартай чадварлаг

сэтгүүлчид төрөн

гарах юм.

«

Сэтгүүлч боловсон хүчин бэлтгэдэг ихэнх сургуулиудад хөтлөгчийн ур чадварын хичээлийг тусгайлан ордоггүйгээс төгсөгчид нь телевизийн сэтгүүлч хөтлөгчийн шаардлагыг хангаж чаддаггүй. Ихэвчлэн СУИС-ийн жүжигчний анги төгссөн, нэг бол сэтгүүлчийн мэргэжил эзэмшээгүй, эфирийн царайтай хүмүүсээр хөтлөгч хийлгэж, сэтгүүлчдийн орон зайг эзлэх болсон.

»

Теле сэтгүүл зүйн сургалт чанар-

тай байх гол зүйл нь мэргэшсэн

чадварлаг багш нар чухал юм. Багш

нарын заах нэг хичээл сургууль тус бүр

дээр харилцан адилгүй. Иймд Монго-

лын сэтгүүл зүйн сургалтын багш

нарын нэгдсэн зөвлөгөөнийг хийж

удирдамж гаргаад ажиллалал үр

дүнтэй байх болов уу гэсэн саналуудыг

дэвшүүлж байна.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Амбасэлмаа Д. 2005. Мянга сонсохоор нэг үзэхүй. УБ.

2. Амарзаяа Л. 2004. Нэвтрүүлэгч, хөтлөгчийн тухай асуудалд // "Сэтгүүл зүй" МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. №236.

3. *Амарзаяа Л.* 2005. Сэтгүүлч, нэвтрүүлэгч, хөтлөгчийн хэл ярианы соёлд холбогдох онол арга зүйн зарим асуудалд // "Сэтгүүл зүй" МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг. №249.
4. *Баасансүрэн Т.* 1999. Сэтгүүлчийн уран чадварын тухай яриа. УБ.
5. *Зулькафиль М.* 1998. Теле сэтгүүлчийн ур чадвар, онол практикийн зарим асуудал // "Сэтгүүл зүй" МУИС-ийн эрдэм шинжилгээний бичиг.
6. *Зулькафиль М.* 2005. Сэтгүүл зүйн тайлбар толь. УБ.
7. *Жаргал С.* 2008. Ярилцлага. "Утга зохиол урлаг" сонин. №10/2279.
8. *Наранжаргал Х.* 2005. Телевизийн сэтгүүл зүй. УБ.
9. *Fiske J.* 1993. Television Culture. London.

10. *Peters H. K.* 1990. Who is journalist. New York.

Resume

My presentation aim is to show how it's going on nowadays teaching of journalism on the television journalist at the Institutes and Universities.

The training of journalism must to demand the television journalist's ability. And I'd like to say the training of journalism must to start at the second course of Universities and to increase it's credit, to train practice of journalists ability also it's have to train the commentator ability lesson at the Institutes and Universities in Mongolia.